



**НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хатуу хөл хорионы дэглэмийн үед ажлын хариуцлагыг сайжруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Засгийн газрын 2020 оны "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" 181 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 34 дүгээр хурлын тэмдэглэл, Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 16 дугаар хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1248, 1250 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст /Ковид-19/ цар тахалтай тэмцэх, халдвар, тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор хатуу хөл хорио тогтоосон дэглэмийн үед Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн албан хаагчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор биеийн халууныг тогтмол үзэж нэвтрүүлэх, гарыг ариутгах, амны хаалтыг зүүж үйлчлүүлэх шаардлагыг тавьж, байгууллагуудаас ирүүлсэн нэрстэй тулгах, ажлын үнэмлэх, иргэний үнэмлэхийн QR кодыг уншуулж, бүртгэх ажлыг зохион байгуулж ажиллахад тухайн байранд ээлжийн ажилтай байр ашиглалтын албаны ажилтнууд нэмэгдэл үүрэг гүйцэтгэж ажиллахыг Байр ашиглалтын албаны дарга /Г.Батзаяа/, Байр хариуцсан менежер нарт тус тус үүрэг болгосугай.

2. НЗЗ-ны байрууд, Баянхошуу, Сэлбэ дэд төвүүдийн байрны жижүүр, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд ажиллаж байгаа цагдаагийн болон харуул хамгаалалтын ажилтнуудын хариуцлагыг өндөржүүлж ажиллахыг Үйлчилгээний албаны дарга /М.Алтантуяа/, Байр хариуцсан менежерүүдэд тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагаар ханган ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга /Ч.Шинэчимэг/ т үүрэг болгосугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



ХЭРДЭНЭБИЛЭГ

1150500124

Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын
 даргын 2020 оны 11 дүгээр сарын 23-ны
 өдрийн 163 дугаар тушаалын хавсралт



НИЙТЭЭР АМРАХ АМРАЛТЫНБОЛОН БАЯРЫН ӨДРҮҮДЭД
 АЖИЛЛАХ ШУУРХАЙ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ НЭРС
 /Шаардлагатай үед/

№	Овог нэрс	Албан тушаал	Утас	Тайлбар
1	Г.Батзаяа	БАА-ны дарга /шуурхай багийн ахлагч /	91912431	
2	Б.Батсүрэн	Цахилгааны инженер	99862983	Нийтээр амрах амралтын өдрүүдэд НЗЗ-ны байруудад гэнэтийн осол аваар, гэмтэл гарсан тохиолдолд тус шуурхай баг нь яаралтай ирж гэмтлийг түргэн шуурхай засаж хэвийн байдалд оруулна. Шуурхай багийн ажилтнуудын утас 24 цагийн нээлттэй байна.
3	Б.Б.Ичинноров	Дулаан, сантехникийн инженер	99168879	
4	О.Оюун-Эрдэнэ	Сантехникийн слесарь	88999831	
5	Г.Лхагвадорж	Сантехникийн слесарь	86746769	
6	О.Лхамсүрэн	Сантехникийн слесарь	96077001	
7	Д.Эрдэнэзул	Сантехникийн слесарь	88846575	
8	Н.Батболд	Сантехникийн слесарь	99755119	
9	Н.Төмөрсүх	Мужаан	91221180	
10	С.Лхагвадорж	Цахилгаанчин	99933414	
11	С.Алтаншагай	Цахилгаанчин	89490818	